



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/119

Улаанбаатар хот

Журам, хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.13 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гемодиализ эмчилгээ, үйлчилгээний журмыг нэгдүгээр, бөөрний архаг дутагдлын үеийн гемодиализ эмчилгээг хийх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээний хуваарийг хоёрдугаар, бөөрний хурц дутагдалд гемодиализ эмчилгээг хийх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээний хуваарийг гуравдугаар, гемодиализ эмчилгээний улирлын тайлангийн загварыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Хуваарийн дагуу гемодиализ эмчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй, чирэгдэлгүй үйлчилж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг гемодиализ эмчилгээ, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт даалгасугай.

3. Эрүүл мэндийн бүртгэл мэдээллийн H-info 3.0 програм хангамжид гемодиализ эмчилгээний нэхэмжлэлийг оруулах тохируулгыг хийж эрүүл мэндийн байгууллагууд нь даатгалын санхүүжилтийг саадгүй авах боломжоор хангахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Нарантуяа/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газрын дарга /Я.Буянжаргал/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Баярт/, Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/ нарт даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2014 оны 303 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

090415

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 30 ны өдрийн  
М. дугаар тушаалын 1 дүгээр  
хавсралт



## Гемодиализ эмчилгээ, үйлчилгээний журам

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь гемодиализ эмчилгээ, үйлчилгээний хүртээмж, чанар, бүртгэл мэдээллийг сайжруулж, үйлчлүүлэгчийн гомдол, чирэгдлийг бууруулахад оршино.
- 1.2. Гемодиализ эмчилгээг Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хөдөлмөрийн хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан журам, стандарт, заавартай уялдуулан энэхүү журмыг мөрдөж ажиллана.
- 1.3. Энэ журмыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар, улсын хэмжээнд гемодиализ эмчилгээ, үйлчилгээ үзүүлж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага нэгэн адил мөрдөн ажиллана.


### Хоёр. Гемодиализ эмчилгээний зохион байгуулалт, бүртгэл, мэдээлэл

- 2.1. Гемодиализ эмчилгээ, үйлчилгээний бодлого, бодлогын хэрэгжилт, нэгдсэн зохицуулалтыг Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар хариуцна.
- 2.2. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нь харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын гемодиализ эмчилгээ, үйлчилгээний хүртээмж, чанарт хяналт тавьж, холбогдох асуудлыг шийдвэрлэж ажиллана.
- 2.3. Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь гемодиализ эмчилгээг улсын хэмжээнд мэргэжил, аргазүйн нэгдсэн удирдлагаар ханган, бүртгэл, мэдээлэлд үндэслэн ачааллыг зохицуулах, хүлээгдлийг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг хариуцан ажиллана.
- 2.4. Эрүүл мэндийн байгууллага тус журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу улирал тутам мэдээллийг гаргаж дараа улирлын эхний сарын 04-ний дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Статистик мэдээллийн технологийн албанд цахим хэлбэрээр хүргүүлнэ.
- 2.5. Эрүүл мэндийн хөгжлийн төв нь улирал бүрийн эхний сарын 10-ны дотор Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламжийн газар мэдээллийг нэгтгэн ирүүлнэ.

## Гурав. Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

- 3.1. Гемодиализ эмчилгээний заавар, стандартын шаардлага хангасан хүний нөөц, аппарат тоног, төхөөрөмж, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлзүйн шинжилгээг хийх лабораторийн урвалж, оношлуурын хангамж, нөөцийг бүрдүүлж тасралтгүй байдлыг хангаж ажиллана;
- 3.2. Гемодиализ эмчилгээг хийх эмч, мэргэжилтний ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарийг тодорхой зааж батлан, мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана;
- 3.3. Иргэний шилжилт хөдөлгөөн болон бусад шалтгаанаар эмнэлгийн харьяалал өөрчлөгдөж, шилжүүлэх шаардлагатай болсон иргэнийг хуанлийн 21 хоногийн өмнө хүлээн авах эмнэлэгт нь урьдчилан мэдээлж, бүртгэлд орсны дараа шилжүүлнэ;
- 3.4. Гемодиализ эмчилгээний аппарат, бусад тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэлгүй ажиллах, тохируулга, урсгал засвар, үйлчилгээг тогтмолжуулж, усны чанар, аюулгүй байдалд тогтмол хяналт тавих нөхцлийг бүрдүүлнэ;
- 3.5. Гемодиализ эмчилгээнд хэрэглэгддэг эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг ханган ажиллах ба эм ханган нийлүүлэх байгууллагын тээвэрлэлтийн горимд хяналт тавьж, шаардлага тавина;
- 3.6. Гемодиализ эмчилгээний хүлээгдэл, үйлчилгээний цагийн хуваарь, цаг товлолын мэдээллийг ил тод байршуулна;
- 3.7. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвд гемодиализ эмчилгээ хийлгэж байгаа өвчтөнд бусад эрхтэн системийн дутагдал, үүсч, хүндэрсэн тохиолдолд улсын хэмжээнд лавлагаа тусламж, үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагад илгээнэ. Энэ тохиолдолд тухайн өвчтөний шилжин очсон эрүүл мэндийн байгууллага хэвтэн эмчлүүлэх хугацаанд нь гемодиализ эмчилгээг таслахгүйгээр өөрийн эмнэлэгт үргэлжлүүлэн хийх ба эмчилгээ дууссаны дараа иргэнийг үндсэн хуваарийн дагуу буцаан шилжүүлнэ;
- 3.8. Эмчлэгч эмч нь үйлчлүүлэгчийн долоо хоногт гемодиализ эмчилгээнд орох сеансын тоог тогтоохдоо батлагдсан эмчилгээ, оношилгооны зааврын дагуу эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг үндэслэн үнэн зөв оновчтой шийдвэрлэн, эмчилгээний үр дүнг тооцож, анхан шатны бүртгэлийн маягтаар баталгаажуулна;
- 3.9. Эмчилгээнд хамрагдаж байгаа үйлчлүүлэгчдэд тогтмол хэрэглэх эм, тариа болон амьдралын хэвшилд нь орох өөрчлөлтийн дагуу тогтмол сургалт хийж, сургалтыг үйлчлүүлэгчийн гарын үсгээр баталгаажуулна;
- 3.10. Гемодиализ эмчилгээ хийх эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтад хамруулж, чадавхийг сайжруулах арга хэмжээг авна;
- 3.11. Гемодиализ эмчилгээний онцлогоос шалтгаалж, эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын цагийн зохицуулалт хийж, цалинг холбогдох эрх зүйн хүрээнд тооцон олгоно.

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 30-ны өдрийн  
А. дугаар тушаалын 2 дугаар  
хавсралт




**Бөөрний архаг дутагдлын үеийн гемодиализийн тусламж, үйлчилгээг  
үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээний хуваарь**

№	Эрүүл мэндийн байгууллага	Тогтмол үйлчлэх хүрээ	Бусад эрхтэн системийн дутагдал үүссэн, хүндэрсэн тохиолдолд
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Хөвсгөл, Төв, Архангай, Баянзүрх 1-11, 13-16, 18, 19, 21, 22, 24-27 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг	Улсын хэмжээнд
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Тушаалаар үйлчлэх албан тушаалтай иргэд, Сүхбаатар дүүргийн иргэд	Улсын хэмжээнд
3	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Баянгол дүүргийн 10-23 хороо Сонгинохайрхан дүүргийн 8-32 дугаар хороо	Улсын хэмжээнд
4	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд	Улсын хэмжээнд
5	Хавдар судлалын үндэсний төв	Хавдартай иргэд, Хан-Уул дүүргийн 1-6 дугаар хороо	Улсын хэмжээнд
6	Цэргийн төв эмнэлэг	Батлан хамгаалах хууль сахиулах албан хаагчид болон тус албанаас тэтгэвэрт гарсан иргэдэд	Улсын хэмжээнд
7	Багануур дүүргийн нэгдсэн эмнэлэг	Багануур дүүргийн иргэд	-
8	Налайх дүүргийн нэгдсэн эмнэлэг	Налайх, Багахангай, Баянзүрх дүүргийн 12, 17, 20,23, 28 дугаар хорооны иргэд	-
9	СХД-ийн Эрүүл мэндийн төв	Сонгинохайрхан дүүргийн 1-7 дугаар хороо	-
10	БГД-ийн Эрүүл мэндийн төв	Баянгол дүүргийн 1-9 дугаар хороо	-
11	ХУД-ийн Эрүүл мэндийн төв	Хан-Уул дүүргийн 7-16 дугаар хороо	-
12	СБД-ийн нэгдсэн эмнэлэг	Сүхбаатар дүүргийн 3,5,7,9,11,18 дугаар хороо	-
13	Дархан уул аймгийн нэгдсэн эмнэлэг	Дархан-Уул аймгийн болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
14	Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Дорнод аймгийн болон үйлчлэх хүрээний аймгийн иргэд	-
15	Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Орхон аймгийн болон үйлчлэх хүрээний аймгийн иргэд	-

16	Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Өмнөговь, Дундговь аймгийн болон үйлчлэх хүрээний аймгийн иргэд	-
17	Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг	Сүхбаатар аймгийн болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
18	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	Аймгийн болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
19	Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Ховд аймгийн болон үйлчлэх хүрээний аймгийн иргэд	-
20	Баян-Өлгийн аймгийн нэгдсэн эмнэлэг	Баян-Өлгийн аймгийн болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд иргэдэд	-
21	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг	Булган аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
22	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	Говь-Алтай аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
23	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг	Дорноговь, Говьсүмбэр аймгийн болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
24	Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Өвөрхангай болон үйлчлэх хүрээний аймгийн иргэд	-
25	Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг	Хэнтий аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
26	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг	Баянхонгор аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
27	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	Увс аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
28	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	Завхан аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэд	-
29	Агапе хоспис	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан иргэд	-
30	Люкс диализ төв	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан иргэд	-
31	Kidney care эмнэлэг	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан иргэд	-
32	ICU эмнэлэг	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан иргэд	-
33	Улаанбаатар мед эмнэлэг	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан иргэд	-
34	Интермед эмнэлэг	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан иргэд	-
35	Эрин эмнэлэг	Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан гэрээний хавсралтаар батлагдсан иргэд	-
36	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг	Хөвсгөл аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэдийг 2017 оны 6 дугаар сараас эхлэн	
37	Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	Хөвсгөл аймаг болон хил залгаа аймгийн ойролцоох сумдын иргэдийг 2017 оны 6 дугаар сараас эхлэн	

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 30 ны өдрийн  
А/119 дугаар тушаалын 3 дугаар  
хавсралт



**Бөөрний хурц дутагдлын үеийн гемодиализ эмчилгээ, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээний хуваарь**

№	Эрүүл мэндийн байгууллага	Үйлчлэх хүрээ
1	Улсын нэгдүгээр төв эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд болон Баянзүрх дүүргийн иргэд
2	Улсын хоёрдугаар төв эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд болон Сүхбаатар дүүргийн иргэд
3	Улсын гуравдугаар төв эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд болон Гэмтлийн шалтгаант бөөрны хурц дутагдалтай иргэд
4	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	Хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд
5	Хавдар судлалын үндэсний төв	Хавдартай иргэд
6	Цэргийн төв эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
7	Багануур дүүргийн нэгдсэн эмнэлэг	Багануур дүүргийн иргэд
8	СХД-ийн Эрүүл мэндийн төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
9	БГД-ийн Эрүүл мэндийн төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
10	ХУД-ийн Эрүүл мэндийн төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
11	Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв	Налайх, Багахангай дүүргийн иргэд
12	Дархан уул аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
13	Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
14	Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд болон Хөвсгөл аймгийн иргэд
15	Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд болон Дундговь аймгийн иргэд
16	Сүхбаатар аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд

17	Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
18	Ховд аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
19	Баян-Өлгийн аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
20	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
21	Говь-Алтай аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
22	Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
23	Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
24	Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
25	Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
26	Увс аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
27	Завхан аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
28	Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд
29	Архангай аймгийн нэгдсэн эмнэлэг	Бөөрний архаг дутагдлын эмчилгээ хийх үйлчлэх хүрээний иргэд

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 03 сарын 30 ны өдрийн  
А/119 дугаар тушаалын 4 дүгээр  
хавсралт

### Гемодиализ эмчилгээний улирлын тайлан

№	Үзүүлэлт	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Нийт дүн
1	Бүгд					
2	Хүйс	Эрэгтэй				
		Эмэгтэй				
3	Нас барсан өвчтөний тоо					
4	Тухайн улиралд шинээр гемодиализэд орсон өвчтөний тоо					
5	5-аас дээш жил гемодиализ эмчилгээнд хамрагдсан хүний тоо					
6	Үйлчлүүлэгчийн харьяалал	Харьяаллын				
		Харьяаллын бус				
7	Өвчний олон улсын ангиллаар	Гломерулонефрит				
		Бөөрний поликистоз				
		Чихрийн шижин				
		Архаг бөөрний тээвшинцрийн үрэвсэл				
		Артерийн даралт ихсэх өвчин				
		Системная красная валчанка				
		Синдром альпорта				
		Бусад				
8	Стандарт эмчилгээнд орсон хүний тоо					
9	Стандарт бус орсон үйлчлүүлэгчийн тоо					
10	Тухайн улиралд хийгдсэн нийт сеансын тоо					
11	Архаг диализын нийт сеансийн тоо					
12	Үүнээс шилжсэн					
13	Вирустэй хүний тоо	Бөөр шилжүүлэн суулгасан				
		Төлбөртэй сеанс				
		БЭСК-ийн диализын тоо				
		Хүний тоо				
		HBs				
	HCV					
14	Вакцинд хамрагдсан хүний тоо					
15	Эмийн хэрэглээ	Эритропоедин хийлгэж байгаа хүний тоо				
		Фосфор холбогч				
		Цинакальцит				
		Витамин D				
16	Хөдөлмөр эрхэлдэг эсэх /тоогоор/	Суралцдаг				
		ажилтай				
		бусдын асаргаанд				
		гэртээ				